



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13.4.1 дэх заалт, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:

Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

А.Алтаншагай

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Одмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Х.Нарангарав

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Н.Дагиймаа

Хүний нөөцийн мэргэжилтэн

2.Байгууллагын ажиллагсдыг ёс зүйн зөрчил гаргуулахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах, холбогдох тайлан мэдээг Ёс зүйн хороонд хүргүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хороо /Н.Ганболд/-д даалгасугай.

3.Ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдэд хурал, бусад арга хэмжээнд оролцсон идэвх, оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улиралд нэг удаа, нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх урамшууллыг сар бүр олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132000005